

Д.Сундуйсүрэн - Удирдахуйн ухааны профессорын багийн
профессор, доктор /Ph.D/, цагдаагийн хурандаа
Х.Баярмаа - Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны
суралцагч, цагдаагийн дэд хурандаа

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЖИЖҮҮРИЙН ШИНЖЭЭЧ МЭРГЭЖИЛТНИЙ ЦАГИЙН МЕНЕЖМЕНТИЙН АСУУДАЛ

Хураангуй. Улс орны нөхцөл байдалтай уялдан техник технологийн салбар хурдацтайгаар хөгжиж, гэмт хэрэгтэй тэмцэхэд криминалистикийн шинжлэх ухааны ололт амжилтыг өргөн ашиглах хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж байна. Ялангуяа хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн өнөөгийн ардчилсан нийгэмд бүх гэмт явдлыг зөвхөн байцаах, залхаах аргаар сэжигтэн, яллагдагчийг айдаст автуулан, хэрэг хүлээх аргагүй байдалд оруулж хэргийг шийдэх биш харин гэмтний хэргийн газарт үлдээсэн мөрөөр нь буюу шинжлэх ухааны үүднээс “мөрдөж нотлох ” ёстой. Хэргийн газарт гэмт үйлдлийн мөр үүсэх нь зайлшгүй гэдгийг олон орны криминалистууд хүлээн зөвшөөрдөг тул хэргийн газраас гэмт үйлдлийн мөр илрүүлэх ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгдөг. Иймээс хэргийн газрын үзлэгээр ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх чиг үүрэг бүхий шинжээч, мэргэжилтнүүдийн цагийн менежментийн асуудлыг судалсан болно.

Түлхүүр үг. Шүүхийн шинжилгээ, шинжээч, мэргэжилтэн, хэргийн газрын үзлэг, ул мөр, эд мөрийн баримт, цагийн менежмент, эрх зүйн зохицуулалт

Оршил

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 63 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Эрүүл мэндийн яамны харъяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэнг нэгтгэн Шүүхийн шинжилгээний үндэсний төв байгуулж, бүтэц, зохион байгуулалтыг баталсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 270 дугаар тогтоолоор Аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, нэгдсэн эмнэлгийн шүүх-шинжээч эмч нарыг нэгтгэн “Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний алба”-ыг байгуулсан.

Тус байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага бөгөөд эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах үндсэн чиг үүрэгтэй ажилладаг. Шүүхийн

шинжилгээний үндэсний хүрээлэн нь Хууль зүй, дотоод хэргийн сайд болон нийт хэрэглэгчийн өмнө чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар хууль зүйн хүрээнд үүрэг, хариуцлага хүлээдэг байгууллага юм.

Үндсэн хэсэг

Гэмт хэргийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нотлох хуулиар хүлээсэн үүргээ чанартай, түргэн шуурхай, хүртээмжтэй явуулахад орчин үеийн дэвшилтэд техник, технологи, шинжилгээний шинэ арга зүй, мэргэжлийн өндөр ур чадвар бүхий хүний нөөцөөс ихээхэн шалтгаалах нь тодорхой бөгөөд хэдийгээр санхүүгийн бэрхшээл байгаа хэдий ч өнгөрсөн жилүүдэд төр засгаас шүүхийн шинжилгээний байгууллагыг бэхжүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ явуулж ирсэн.

Үүний нэг тод жишээ бол өмнө нь тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг байсан шинжилгээний байгууллагуудыг нэгтгэж Шүүхийн шинжилгээний албыг улсын хэмжээнд ажиллуулж, 21 аймаг, нийслэлийн дүүргүүдэд гарын хээний нэгдсэн “Папилон” сан ажиллаж, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ажлын байр шинээр ашиглалтанд орж, галт зэвсгийн хонгио, хошууны “Арсенал” систем, ДНК шинжилгээний лаборатори, автотехникийн шинжилгээний лаборатори зэрэг олон лабораториуд шинээр байгуулагдан ажиллаж байна.

Түүнчлэн криминалистикийн шинжээч, мэргэжилтнүүдээ Дотоод хэргийн их сургууль болон ОХУ-ын ДЯЯ-ны харьяа сургуулиудад бэлтгэдэг.

Шүүхийн шинжилгээний тухай хууль нь 2009 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан бөгөөд энэ хууль батлагдсан. Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндэс бүрдэхэд чухал ач холбогдолтой болсон боловч практикт зарим тулгамдсан асуудал гарсаар байна. Өөрөөр хэлбэл байгууллагын үйл ажиллагааны үр дүнд эерэгээр нөлөөлөх техник хэрэгслийн шинэчлэл, мэргэжилтэй хүний нөөц, ажлын байраар зохих түвшинд хангагдсан билээ.

Харин тухайн байгууллагын хувьд алба хаагчдын цагийн менежменттэй холбоотой анхаарвал зохих хэд хэдэн асуудал байдаг. Байгууллагын цагийн менежмент бол бүтээмжтэй ажиллах, цаг хугацааг хэрхэн үр дүнтэй зарцуулах үйл ажиллагааг удирдах, хянах төлөвлөгөөт үйл ажиллагаа болох баримт бичгийн хослол юм. Байгууллага нь хувь хүний авъяас чадварыг нэмэгдүүлэх, өмнөө тавьсан зорилгоо биелүүлэхэд цаг хугацааг хэрхэн ашиглах чадварыг нэмэгдүүлэх, цаг төлөвлөлт, хуваарилалт, зорилгоо зөв тодорхойлох, хосолсон ажил үүрэг, цаг зарцуулалтад хяналт тавих, төлөвлөгөө боловсруулах болон ажил үүргээ хийх дарааллаар эрэмбэлэх зэргийг алба хаагчдад төлөвшүүлэх хүрээнд цагийн менежменттэй холбоотой тодорхой ажлуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Шүүхийн шинжилгээний байгууллагад ажиллаж буй нийт ажилтан, албан хаагчдын ажлын цагийн хуваариар нь ангилж үзвэл:

1. Ажлын 8 цагаар ажилладаг албан хаагчид

2. Ажлын 24 цагаар ажилладаг буюу хоногийн хугацаанд үүрэг гүйцэтгэдэг жижүүрийн албан хаагчид гэж хувааж үзэж болно.

Судлаач миний зүгээс тухайн байгууллагад ажилладаг жижүүрийн шинжээчийн үүрэг гүйцэтгэдэг шинжээч, мэргэжилтнүүдийн ажлын цагийн менежментийн зарим асуудлыг хөндөхөөр энэхүү өгүүллээ бичиж байна.

Учир нь “Цагийн менежмент” нь тодорхой үйл ажиллагаанд зарцуулсан цаг, ялангуяа үр ашиг, үр нөлөө, бүтээмжийг нэмэгдүүлэх байдлыг ухамсартайгаар хянах, төлөвлөх үйл явц байдаг тул албан хаагчдын ажлын цагийг үр дүнтэй ашиглах нь тухайн хүн өөрийн хүссэн цагтаа болон тухайн цаг үеийн шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаандаа цагаа зарцуулах эсвэл удирдах “сонголтыг” хийж¹ чадах эсэхийг тогтоох зорилгоор жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг албан хаагчдын цагийн менежментийн асуудлыг хөндөж байна.

Мөн энэ сэдвийн хүрээнд Шүүхийн шинжилгээний байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн 2 чиг үүргийг хоногийн хугацаанд хэрэгжүүлж ажилладаг албан хаагчдыг сонгосон нь онцлогтой юм.

Учир нь хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн өнөөгийн ардчилсан нийгэмд бүх гэмт явдлыг зөвхөн байцаах, залхаах аргаар сэжигтэн, яллагдагчийг айдаст автуулан, хэрэг хүлээх аргагүй байдалд оруулж хэргийг шийдэх биш харин гэмтний хэргийн газарт үлдээсэн мөрөөр нь буюу шинжлэх ухааны үүднээс “мөрдөж нотлох” ёстой. Хэргийн газарт гэмт үйлдлийн мөр үүсэх нь зайлшгүй гэдгийг олон орны криминалистууд хүлээн зөвшөөрдөг тул хэргийн газраас гэмт үйлдлийн мөр илрүүлэх ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгдөг.

Мөн олон оронд хийсэн судалгааны дүнгээс харахад тухайн байгууллагын үйл ажиллагааны эцсийн үр дүн буюу бүтээмж нь дараах гурван гол хүчин зүйлсээс хамаардаг болох нь тогтоогдсон. Үүнд:

- Байгууллагын хөгжлийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох;
- Хүний нөөцийн чадварыг бүрэн хөгжүүлж ашиглах;
- Ажлын байрны тааламжтай орчинг бүрдүүлэх;

Дээрх асуудлуудыг цогц байдлаар шийдсэн үед л тухайн байгууллагын бүтээмж өсдөг байна. Тэгвэл жилийн 365 хоногийн турш дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүд дээр ээлжээр тасралтгүй үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ажлын үр дүнд /бүтээмжид/ нөлөөлж байгаа хүчин зүйлийг

¹ Stella Cottrell (2013). The Study Skills Handbook. Palgrave Macmillan, pp. I23+. ISBN 978-1-137-28926-1.

тодорхойлох, цаашид хэрхэх талаар санал дүгнэлт боловсруулах шаардлагатай юм.

Харин сүүлийн жилүүдэд нийслэлийн хэмжээнд цагдаагийн хэлтсүүд шинээр байгуулагдаж, түүнд ээлжээр үүрэг гүйцэтгэх жижүүрийн шинжээчийн орон тоо хүрэлцэхгүйн улмаас ажлын цагийн үргэлжлэх хугацаа нэмэгдэж, ээлж хоорондын амралт 24 - 48 цаг болсон нь холбогдох хууль тогтоомжийг зөрчихөөс гадна алба хаагчийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж эцэстээ ажлын бүтээмжийг бууруулж байна.

Иймд энэ асуудлыг хууль эрх зүйн болон удирдлага, зохион байгуулалтын хүрээнд оновчтой шийдвэрлэх шаардлагатай үүсч байдаг.

Гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх чиг үүргийг цаг алдалгүй тухай бүрд нь хэрэгжүүлж, энэхүү үйл ажиллагааг шөнийн цагаар ч тасралтгүй явуулахын тулд хууль сахиулах байгууллагын зарим алба хаагчид ээлж¹ээр ажиллаад нэлээд хугацаа өнгөрчээ.

Гэвч энэ хугацаанд хэргийн газрын үзлэгт оролцдог жижүүрийн алба хаагчдын ажлын цаг, ажиллах нөхцөл, эрүүл мэнд, эрх зүйн баталгаа зэрэг нийгмийн асуудлыг эрх зүйн болон удирдлага, зохион байгуулалтын хүрээнд бүрэн шийдвэрлэхгүйгээр өдий хүрсэн. Ер нь бол байгууллагын үйл ажиллагааг хэвийн, үр дүнтэй явуулахын тулд алба хаагчийн ажиллах нөхцөл, эрх зүйн баталгааг судалж ажлын үр дүнг сайжруулах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй. Алба хаагч гэдэг нь тухайн байгууллагын болоод салбарын хувьд, цаашлаад улс орны хувьд хамгийн чухал баялаг байдаг.

Уг нь жижүүр²-ийн алба хаагч нь тогтсон ажлын цагаар ажиллаж, ээлж хоорондын амралтаа хууль ёсоор бүрэн эдэлж чадвал алба хаагчийн хөдөлмөрийн чадвар алдалт багасч, хөдөлмөрийн чадвараа нөхөн сэргээх, өөрийн эрүүл мэнддээ анхаарах, сурч боловсрох, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, ар гэр, амьдарч буй орчныхоо ая тухтай байдлыг сайжруулах зэргээр нийгмийн асуудлаа зохицуулах боломж бүрдэнэ.

Гэвч жижүүрийн алба хаагчийн хийж гүйцэтгэх үндсэн ажил нэг хоногийн хугацаанд дуусах боломжгүй байдгаас шалтгаалан тогтмол илүү цагаар ажиллаж байна.

Юун түрүүнд “Жижүүрийн шинжээч, мэргэжилтэн” гэсэн ойлголтыг цаашид тогтсон нэг утгаар ойлгохын тулд шүүхийн шинжилгээний байгууллагын эрх зүйн актууд болон ном, сурах бичиг, эрдмийн бүтээлүүдийг судалж үзэхэд жижүүрийн шинжээч, мэргэжилтний ажлын цаг, ажиллах

¹ Монгол хэлний их тайлбар толь бичиг, “юмны халагдан солилцох дараалалыг ээлж, тогтсон хугацаанд дэс дараагаар халаа солилцон ажиллахыг ээлжлэн ажиллах, тодорхой цагаар ээлжлэн солигдохыг ээлжийн ажил гэнэ”

² Монгол хэлний их тайлбар толь бичиг, “Ээлжийн журмаар үүрэг гүйцэтгэх хүн”

нөхцөл, эрх зүйн баталгааг журамлан тогтоосон эрх зүйн нэг ч зохицуулалт дурдагдаагүй байна. Мөн “жижүүрийн шинжээч” гэсэн ойлголт нь одоог хүртэл нэгдсэн нэг ойлголт болж тодорхойлогдоогүй байна.

Харин хууль зүйн ухааны доктор, дэд профессор Б.Лхагвасүрэн “Криминалистикийн шинжээч гэдэг нь тусгай мэдлэг эзэмшсэн, тухайн мэдлэгийн салбартаа мэргэшсэн, судлан шинжилж буй зүйлийнхээ талаар нэвтэрхий мэддэг, туршлагатай хүн”¹ гэж тодорхойлсон байна. Харин ОХУ-ын нэртэй криминалист эрдэмтэн Н.П.Майлис “Криминалистикийн шинжээч гэдэг нь шинжилгээний онол, аргачлал, дадлын тусгай мэдлэгийг эзэмшсэн, шинжлэх ухаан, практикийн үйл ажиллагааг сайн мэдэх туршлага, мэдлэгтэй хүн” гэж тодорхойлжээ.^{1 2}

Иймээс дээрх эрдэмтдийн тодорхойлолтонд тулгуурлан 24 цагийн хугацаагаар ээлжлэн солигдож, харъяа нутаг дэвсгэртээ гарсан гэмт хэргийн үзлэгт мэргэжилтнээр оролцож, хэргийн газраас ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэн улмаар шинжилгээ хийлгэх эрх бүхий албан тушаалтлан, байгууллагын тогтоол, захирамж, хүсэлтийн дагуу криминалистикийн шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээчийг цаашид “жижүүрийн шинжээч” гэж нэрлэвэл зохистой гэж үзлээ. Нөгөө талаараа жижүүрийн шинжээч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаа болох үзлэг, нэгжлэг, загвар авах зэрэгт мөрдөгчийн дуудсанаар оролцож байгааг “мэргэжилтэн” гэж ойлгож болно.

Ингээд нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын жижүүрийн шинжээч, мэргэжилтний хоногт гүйцэтгэж буй ажлын ачааллыг шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн бодитой тодорхойлж, тус газрын ажлын үндсэн үйл ажиллагааны үр дүнд учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх арга замыг оновчтой тодорхойлохыг зорилоо.

Зорилт №1-ийн хүрээнд хийсэн судалгааны хэсэг:

Нийслэлийн шүүхийн шинжилгээний газарт сүүлийн 5 жилийн хугацаанд ажилласан алба хаагчдын тоог жил тус бүрээр нь гаргаж түүнээс дунд болон богино хугацааны сургалтад хамрагдсан, жирэмсний болон амаржсаны амралт эдэлсэн алба хаагчдын ажлаас чөлөөлөгдсөн хугацааг нарийвчлан тооцож, ажиллаагүй нийт хугацааг алба хаагчийн тоонд хөрвүүлэн шилжүүлж, нийт ажилласан алба хаагчдын бодит тоог гаргаж, гарсан үр дүнг 2017-2020 онд тус газраас гаргасан гэмт хэргийн газарт ажилласан статистик мэдээтэй математик статистикийн аргаар харьцуулж нэг шинжээч, мэргэжилтний жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын бодит ачааллыг тодорхойллоо.

¹ Б.Лхагвасүрэн, Криминалистикийн шинжилгээ судлал, УБ, 2010, 88 дахь тал,

² Майлис.Н.П, Моя профессия-судебный эксперт, Москва, 2006,

Нийслэлийн шүүхийн шинжилгээний газарт нийт жижүүрийн 68 шинжээч, мэргэжилтэн ажилладаг. Жилийн хугацаанд алба хаагчдын зайлшгүй эдлэх ээлжийн амралт, амаржсаны амралт, богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан алба хаагчдын ажлаас чөлөөлөгдсөн хугацаа нь жилд дунджаар 16 сар байгаа нь нэг тасгийн алба хаагчдын нэг жилд хэвийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх хугацаанд дүйцүүлэн бодохоор ээлж хоорондын амралтын хугацаа 72 цаг байх ямар ч боломжгүй байна.

Хүснэгт №1.

Огноо	Нийслэлийн хэмжээнд хийгдсэн нийт ХГҮ	Шинжээчийн тоо	Амаржсаны амралт авсан хүний тоо	Дунд болон богино хугацааны сургалтад хамрагдсан хүний тоо	Чөлөөлөгдсөн хугацаа /сараар/	Хугацааг хүний тоонд хөрвүүлэн шилжүүлсэн	Тухайн жилд бүтэн ажилласан алба хаагчдын	Нэг хүнд ногдох ХГҮ	Ээлж хоорондын амралт 48 цаг байхад нэг хоногт нэг хүн оролцох ХГҮ-ийн дундаж
2016 он	13669	37	4	5	4	3	34	402	3.3
2017 он	19019	69	4	9	4	4.3	65	292	2.4
2018 он	18674	70	5	10	4	5	65	287	2.4
2019 он	21246	69	4	11	4	5	64	332	3
2020 он	27385	68	6	10	4	5.3	63	435	4

/Жич: Шинжээч мэргэжилтнүүдийн бүртгүүлсэн газрын статистик мэдээнд суурилсан/


Зорилт №2-ын хүрээнд хийсэн судалгааны хэсэг:

Хэргийн газрын үзлэгийг эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд жижүүрийн шинжээч, мэргэжилтэн нь хэргийн газарт байж мэргэжилтнээр оролцдог. Хэргийн газрын үзлэгийг тогтсон үе, шатуудыг дамжин хийх нь үзлэг чанартай болох, зөв таамаглал дэвшүүлэх, мөр нотлох баримтын шинж чанараа хадгалах, гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх зэрэг ач холбогдолтой. Харин тодорхой логик дэс дараалал бүхий үе, шатын нэгийг алгасах, дэс дарааллыг нь гажвал дээр дурдсан ач холбогдлыг алдах аюултай.

Тиймээс жижүүрийн шинжээч, мэргэжилтнүүдийн нэг хэргийн газрын үзлэгийг тогтсон үе, шатуудыг дамжин ажиллахад ямар хугацаа зарцуулахыг бодитой тооцох зорилгоор 24 цагийн хугацаанд хийж гүйцэтгэж буй үндсэн

ажлын талаарх судалгааг анкет асуулгын аргаар авч, нэг хоногийн ажлын ачаалалыг бодитойгоор тодорхойлохыг зорилоо. Ингэснээр шинжээч, мэргэжилтний нэг хэргийн газарт хийх үзлэг болон хоногт хийж гүйцэтгэдэг бусад ажиллагаанд зарцуулдаг бодит хугацааг тодорхойлж, хоногийн 24 цагийн хугацаанд хийж гүйцэтгэх ажлын бодит ачаалалыг харуулна.

Асуулгын эхэнд жижүүрийн шинжээч, мэргэжилтнүүдийн нэг хоногт оролцдог хэргийн газрын үзлэгийн дундаж тоог тодорхойлсон. Ээлжийн албан хаагчдаас авсан “Хоногт дунджаар хэдэн гэмт хэрэг, зөрчлийн дуудлагад явдаг вэ?” гэсэн асуултанд алба хаагчдын 8.6% нь 1-4, 62.8% нь 5-9, 22.8% нь 10-14, 5.7% нь 15-20 гэж хариулсан бөгөөд хариултаас дүгнэхэд хоногт дунджаар нэг алба хаагч хэргийн газрын 7 үзлэгт оролцдог гэсэн тоон мэдээ гарч байна. Үр дүнг доорх графикаар харуулав.



Мөн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн газар нутгийн хэмжээ, хүн амын нягтаршил, оршин суугчдын амьдралын түвшин зэргээс шалтгаалж хоногт гардаг гэмт хэргийн тоо бусад дүүргүүдээс харьцангуй их байдаг учраас эдгээр дүүргүүдийн гэмт хэргийн мэдээг математик статистикийн аргаар дүгнэж үзэхэд нэг жижүүрийн шинжээч, мэргэжилтний хоногийн хугацаанд оролцох хэргийн газрын үзлэгийн тоо 10 байна.

Хоногийн хугацааны дуудлага мэдээллийн тоо харьцангуй өөр өөр байдгаас шалтгаалан НШШГ-ын сүүлийн нэг сарын хугацааны хоногийн мэдээнээс шүүж үзэхэд нэг хоногт хамгийн ихдээ 14 хэргийн газрын үзлэгт оролцсон байна.

Судалгааны явцад гаргасан нэг жижүүрийн шинжээч, мэргэжилтний хоногийн хугацаанд оролцох хэргийн газрын үзлэгийн 4, 7, 10, 14 гэсэн тоон үзүүлэлтүүдийг алба хаагчдаас авсан хугацаа зарцуулалтын санал асуулгын үр дүнтэй нэгтгэн тооцож хүснэгт №2, 3-аар тус тус харуулав.

Хэргийн газарт ажиллах үе шатуудын хугацаа зарцуулалт

Хүснэгт №2.

№	Үзлэгийн үе шатууд	Хэргийн өнгө	
		Учрал	Бусад
1	Гэрэл зураг бэхжүүлэх хугацаа	30 минут	30 минут
2	Гутлын мөр, тээврийн хэрэгслийн мөр илрүүлж, бэхжүүлэх хугацаа	15 минут	15 минут
3	Эвдлэгч багаж, хэрэгслийн мөр илрүүлж, бэхжүүлэх хугацаа	15 минут	15 минут
4	Гарын мөр илрүүлж, бэхжүүлэх хугацаа	30 минут	30 минут
5	Биологийн гаралтай ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх хугацаа	30 минут	30 минут
6	Бусад ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх хугацаа	15 минут	15 минут
7	Илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримтаа хаяглан битүүмжилж хүлээлгэн өгөх хугацаа	30 минут	30 минут
8	Цогцосны үзлэг хийх хугацаа	30 минут	
	Зарцуулах нийт хугацаа	195 минут	165 минут

Шинжээч, мэргэжилтний нэг хоногт хийж гүйцэтгэх үндсэн ажлын хугацаа зарцуулалт

Хүснэгт №3.

	Хоногт оролцсон хэргийн газрын үзлэгийн тоо/ХГҮ/			
	4 ХГҮ	7 ХГҮ	10 ХГҮ	14 ХГҮ
Хэргийн өнгө	Бусад-4	Нийт-7 Учрал-1 Бусад-6	Нийт-10 Учрал-1 Бусад-9	Нийт-14 Учрал-1 Бусад-13
Хэргийн газрын үзлэгт зарцуулах хугацаа	Бусад 4x165мин=660 мин	Учрал 1x195=195мин Бусад 6x165=990мин	Учрал 1x195=195мин Бусад 9x165=1485мин	Учрал 1x195мин=195 мин Бусад 13x165мин=2145 мин
Хэргийн газар хооронд зорчих хугацаа	4x45мин=180 мин	7x45мин=315 мин	10x45мин=450 мин	14x45мин=630 мин

Тухайн төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнээр заналхийлэгч этгээдийн үйл хөдлөлийг хянах, гадны довтлого, аюул, эрсдлээс хамгаалахад чухал үр дүнтэй алхам болох юм.

Ном зүй:

1. Монгол Улсын Үндсэн хууль.УБ. 1992 он
2. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль. УБ. 2014 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017 он
4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код. УБ. 2018 он
5. Т.Оюунчимэг. Гэрч. УБ. 2013 он
6. Д.Энх-Амгалан. Гэрч, хохирогчийг хамгаалах асуудал. УБ. 2013 он
7. П.Батбаатар. Гэрч хохирогчийн аюулгүй байдлын онол практикийн асуудал. 2021 он
8. ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн тоон мэдээ. УБ. 2020 он
9. <https://www.Jegalinfo.mn/annex/details/65697lawicM0750>
10. <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5726.pdf> /Турк улсын хууль /
11. [http://base.garant.ru/12136633/Оросын холбооны улсын хууль/](http://base.garant.ru/12136633/Оросын_холбооны_улсын_хууль/)